# МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

# АЛСЫН ХАРАА 2050

ХБТХОХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ж.УЯНГА

# СУУРЬ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

**Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын гол цөм:**
Хөгжлийн бодлогын зорилго бүр Монгол хүний сайн сайхан байдлыг дээшлүүлэх

ХҮНИЙ ХӨГЖИЛ

Эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, эх оронч, хөрвөх, чадвартай, бүтээлч иргэнтэй улс болох.

# АЛСЫН ХАРАА

Монгол Улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болно.






- 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт **“Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна”**
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 7.4-т **“Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын төслийг Засгийн газар өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална”**

**УИХ-ын 2020 оны 5 сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдсан.**

# ЭРХЭМ ЕСӨН ЗОРИЛГО

“Алсын хараа 2050, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого” нь суурь 9 зорилго, 47 зорилттой

ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

ХҮНИЙ ХӨГЖИЛ

АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

ЭДИЙН ЗАСАГ

ЗАСАГЛАЛ

НОГООН ХӨГЖИЛ

АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ

# ЭРХЭМ ЕСӨН ЗОРИЛГО

**НЭГ. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ**
Үндэсний нэгдмэл үнэт зүйлийн гүн ухамсар дархлаатай улс үндэстэн болно

**ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ**
Монгол Улсын Хүний хөгжлийн индексийг 0.9-д хүргэж, аз жаргалын индексээр дэлхийн эхний 10 орны тоонд багтана

**ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА**
Сэтгэл хангалуун амьдрах нөхцөлөөр тэтгэгдсэн дундаж давхаргыг 2050 он гэхэд нийт хүн амын 80 хувьд хүргэнэ

**ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ**
ДНБ 6.1 дахин нэмэгдэж нэг хүнд ногдох ДНБ 3.6 дахин өсөж, 15,000 ам.долларт хүрч, дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын босгыг давна

**ТАВ. ЗАСАГЛАЛ**
Тогтвортой засаглал тогтож, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ѐсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно

**ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ**
Ногоон хөгжлийг эрхэмлэн байгаль орчны тогтвортой байдлыг хангана

**ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ**
Үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалах гадаад дотоод таатай орчин бүрдэнэ

**НАЙМ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ**
Бүс нутгийн эдийн засгийн интеграцад нэгдсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, өрсөлдөх чадвартай улс доторх бүсүүдийг хөгжүүлнэ

**ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ**
Амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй хот болгон хөгжүүлнэ

# СУУРЬ ЕСӨН ЗОРИЛГО, ХӨГЖЛИЙН 47 ЗОРИЛТ

**НЭГ. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ**
Үндэсний бахархал, эв нэгдэл
Нүүдлийн соѐл иргэншилт монгол
Монгол хэл, бичиг
Эрдэм судлал-нийгмийн соѐн гэгээрэл
Дэлхийн монгол

**ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ**
Боловсрол
Эрүүл мэнд
Гэр бүл
Шинжлэх ухаан, инновац
Хүнд ээлтэй амьдрах орчин
Хөдөлмөрийн зах зээл
Монгол хүний удмын сан

**ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА**
Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл Орлогод нийцсэн орон байр
Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес
Дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт
Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг
Газрын харилцаа

**ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ**
Чинээлэг монгол
Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд
Ухаалаг санхүүгийн зах зээл
Бүс нутгийн хамтын ажиллагаа
Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн
Үндэсний баялгийн сан

**ТАВ. ЗАСАГЛАЛ**
Ухаалаг засаглал
Ухаалаг бүтэц
Цахим монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем)
Чадварлаг, ѐс зүйтэй төрийн алба
Хүний эрхийг дээдэлсэн нийгэм Авлигагүй засаглал

**ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ**
Эх байгаль анхдагч экосистем
Байгалийн баялгийн үр өгөөж
Үнэт баялаг ус
Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил

**ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ**
Зэвсэгт хүчин
Дархан хил
Хүн, нийгмийн амар тайван байдал
Хууль сахиулах салбарын хөгжил
Мэдээллийн аюулгүй байдал

**НАЙМ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ**
Дэд бүтэц
Аялал жуулчлал
Тогтвортой хөдөө аж ахуй

**ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ**
Хүн төвтэй хот
Орчин төвтэй шийдэл
Төлөвлөлт төвтэй хөгжил
Хотын сайн засаглал
Дагуул хот

# ХӨГЖЛИЙН ҮЕ ШАТ

10 жилээр буюу 2021-2030 он, 2031-2040 он, 2041-2050 он гэсэн 3 үе шаттайгаар зорилт тус бүрийн үйл ажиллагааны чиглэлийг төлөвлөсөн.

III үе шат
2041-2050

II үе шат
2031-2040

I үе шат
2021-2030


АЛСЫН ХАРАА 2050
Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
Дундговь аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
Сумын Засаг даргын үйл ажиллалгааны хөтөлбөр

# Шинэ сэргэлтийн бодлого

# ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДРИЙН 106 ДУГААР ТОГТООЛ**

**ХАВСРАЛТ № 1**
ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО

**6** чиглэл
**29** зорилт

**ХАВСРАЛТ № 2**
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

**98**
үйл ажиллагаа

**ХАВСРАЛТ № 3**
ХӨГЖЛИЙН ТӨСЛҮҮД

**20**
хөгжлийн төсөл

**ХАВСРАЛТ № 4**
УИХ-ААР НЭН ЯАРАЛТАЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЖАГСААЛТ

**7**
хуулийн төсөл

**ХАВСРАЛТ № 5**
УИХ-Д 2022 ОНД ҮЕ ШАТТАЙГААР ӨРГӨН МЭДҮҮЛЖ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЖАГСААЛТ

**20**
хуулийн төсөл

# КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ







**ЭДИЙН ЗАСАГ СЭРГЭЖ БАЙГАА Ч ДЭМЖИХ ШААРДЛАГАТАЙ**

## МОНГОЛ УЛСЫН

# ЭКСПОРТЫН БҮТЭЦ

(2021 оны байдлаар)

### НИЙТ ЭКСПОРТ

УУЛ УУРХАЙ **92%**

- ЗЭСИЙН ХҮДЭР, БАЯЖМАЛ 31%
- ЧУЛУУН НҮҮРС 30%
- МӨНГӨЖӨӨГҮЙ АЛТ 11%
- ТӨМРИЙН ХҮДЭР, БАЯЖМАЛ 10%
- БУСАД 10%

МАЛ АЖ АХУЙ **4%**

АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ **3%**

ГАЗАР ТАРИАЛАН **0.2%**

**90%** нэмүү өртөг шингээлгүйгээр экспортлодог

### БОЛОВСРУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ

**90%** импортоор худалдан авдаг

# МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦОО



## ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО
## ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО



1. Боомт
2. Эрчим хүч
3. Аж үйлдвэржилт
4. Улаанбаатар хотын түгжрэл
5. Байгалийн нөөц
6. Төрийн бүтээмж

**“АЛСЫН ХАРАА–2050”** хэрэгжилтийг хангах нөхцөлийг хангах

Хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлсийг шийдвэрлэх

Коронавируст халдварын сөрөг нөлөөг бууруулах

**ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН** идэвхтэй оролцоонд тулгуурлан эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг хийх

| Боомтын сэргэлт | Эрчим хүчний сэргэлт | Аж үйлдвэржилтийн сэргэлт | Хот, хөдөөгийн сэргэлт | Ногоон хөгжлийн сэргэлт | Төрийн бүтээмжийн сэргэлт | Нийт төсөл |
|---|---|---|---|---|---|---|
| 6 | 4 | 5 | 2 | 2 | 1 | 20 |
| 44 | 21 | 15 | 6 | 5 | 3 | 94 |

# ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО: БООМТЫН СЭРГЭЛТ

### БООМТЫН ХҮЧИН ЧАДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

Боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.

### ХИЛИЙН БООМТЫГ ТӨМӨР БОЛОН АВТО ЗАМААР ХОЛБОХ

Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.

### АГААРЫН ТЭЭВРИЙН ХҮЧИН ЧАДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

Монгол Улсын агаарын зайн зохион байгуулалт, агаарын замын ашиглалтыг сайжруулан, дамжин өнгөрөх агаарын хөлгийн тоог нэмэгдүүлж, агаарын тээврийн либералчлалыг үе шаттай үргэлжлүүлэх замаар ачаа тээврийн зангилаа төвийг бий болгож, мөн аялал жуулчлалын салбарыг дэмжинэ.

### ХУУРАЙ БООМТЫГ ХӨГЖҮҮЛЭХ

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан эдийн засгийн чөлөөт бүс, хуурай боомтуудыг үе шаттайгаар байгуулах замаар худалдааны эргэлтийг нэмэгдүүлнэ.

# ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО: ЭРЧИМ ХҮЧНИЙ СЭРГЭЛТ

### ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭ ЭХ ҮҮСВЭРҮҮДИЙГ БИЙ БОЛГОХ

Эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх, шугам сүлжээг шинээр барьж байгуулан, хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлнэ.

### СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

Сэргээгдэх эрчим хүчийг зохистой харьцаагаар хөгжүүлэн, усан болон хуримтлуурын станц барьж, эрчим хүчний нэгдсэн системийн найдвартай, тогтвортой байдлыг хангана.

### САЛБАРЫН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БИЕ ДААСАН ТОГТОЛЦООНД ШИЛЖҮҮЛЭХ

Эрчим хүчний салбарыг санхүү, эдийн засгийн бие даасан тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлнэ.

### ЗҮҮН ХОЙД АЗИЙН СУПЕР СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ

Зүүн Хойд Азийн супер сүлжээнд эрчим хүч нийлүүлэх сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр, сүлжээнд холбогдох хэт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын бэлтгэл ажлыг хангана.

### МОНГОЛ УЛСЫН ГАЗАР НУТГААР ДАМЖИН ӨНГӨРӨХ БАЙГАЛИЙН ХИЙ ДАМЖУУЛАХ ХООЛОЙ

Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу Монгол Улсын газар нутгаар дамжин өнгөрөх байгалийн хий дамжуулах хоолой барих бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.

# ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО: АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН СЭРГЭЛТ

**НЭМҮҮ ӨРТӨГ ШИНГЭСЭН УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ**

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг бүрэн цахимжуулж, өртөг зардлыг бууруулан, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дэвшилтэт техник, технологид суурилсан, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээг дээшлүүлэн, эрдэс баялгийн баталгаат нөөцийг арвижуулна.

**НЭМҮҮ ӨРТӨГ ШИНГЭСЭН ҮЙЛДВЭРЛЭЛ ХӨГЖҮҮЛЖ, ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ**

Нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоодын бүтээн байгуулалтын хэрэгцээг хангаж, экспортыг нэмэгдүүлнэ.

**ГАЗРЫН ТОСНЫ БАТАЛГААТ НӨӨЦ ӨСГӨЖ, ОЛБОРЛОЛТ НЭМЭГДҮҮЛЭХ**

Газрын тосны баталгаат нөөцийг өсгөж, олборлолтыг нэмэгдүүлэх замаар дотоодын газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангана.

**ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИД ТУЛГУУРСАН ХӨДӨӨ АЖ АХУЙГ ХӨГЖҮҮЛЭХ**

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэвшилтэт техник, технологи, инновацид тулгуурлан хөгжүүлж, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ.

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ТҮҮХИЙ ЭД БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ХҮЧИН ЧАДАЛ НЭМЭГДҮҮЛЭХ**

Хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүний нөөцтэй уялдуулан боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хагас боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хувь хэмжээг бууруулан, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.

**ШИНЖЛЭХ УХААН, ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ, БЛОКЧЕЙН НЭВТРҮҮЛЭХ**

Шинжлэх ухаанд суурилсан, өндөр технологи, блокчейн, хиймэл оюуны олонтыг нэвтрүүлж, дижитал эдийн засгийн чиг хандлагад нийцсэн аж үйлдвэржилтийг хөгжүүлнэ.

# ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО: НОГООН ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТ

### УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ СААРУУЛАХ

Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад дорвитой хувь нэмэр оруулах зорилгоор "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг үр дүнтэй өрнүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

### ГАДАРГЫН УСНЫ ТОХИРУУЛГА ХИЙЖ, ЗҮЙ ЗОХИСТОЙ АШИГЛАХ, УСНЫ ТОГТВОРТОЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ

Усны нөөцийг хамгаалж, хүн амыг баталгаат ундны усаар хангах, бэлчээрийг усжуулах, говийн бүс нутгийн усны хангамжийг нэмэгдүүлэх, саарал усыг дахин ашиглах, хиймэл нуур, хөв цөөрөм байгуулж, ширгэсэн гол горхи, булаг, шандыг нөхөн сэргээнэ.

### ХОГ ХАЯГДАЛ ДАХИН БОЛОВСРУУЛАЛТЫН ТҮВШИНГ НЭМЭГДҮҮЛЭХ

Байгальд ээлтэй дэвшилтэт технологи бүхий хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүдийг Улаанбаатар хот болон аймаг, орон нутагт бүсчлэн байгуулна.

### БАЙГАЛЬ ОРЧНОО ХАМГААЛЖ, НОГООН ХӨГЖЛИЙН ЖИШИГ ЗАГВАР ТОДОРХОЙЛОХ

Эдийн засаг, аж үйлдвэржилтийн сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхдээ байгаль хамгаалах үндэсний уламжлалт ёс заншлыг хадгалж, дэлхийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн ногоон хөгжлийн жишиг загварыг тодорхойлно.

# ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО: НОГООН ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТ – БАЙГАЛЬ ОРЧИН

**СҮҮЛИЙН 80 ЖИЛД АГААРЫН ДУНДАЖ ТЕМПЕРАТУР**

**2.4 ХЭМ ӨССӨН**

**1 ХҮНД НОГДОХ ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ ДЭЛХИЙН ДУНДЖААС**

**2.7 ДАХИН**



Цөлжилт,
газрын доройтол

**76.9%**



Сүүлийн 20 жилд гамшигт
үзэгдлийн давтамж

**2 ДАХИН ӨССӨН**



Нийт усны нөөцөд эзлэх
гадаргын усны хэмжээ

**98%**



Ойгоор
бүрхэгдсэн талбай

**7.9%**



Дахин боловсруулсан
хог хаягдал

**10%**

# ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО: НОГООН ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТ

| | | |
|---|---|---|
| "ТЭРБУМ МОД" ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН | 600 МЯН.ГА ТАЛБАЙД МОД ТАРИНА. | НЭН ХҮЧТЭЙ ЦӨЛЖСӨН ГАЗАР НУТГИЙН 4%-Г НӨХӨН СЭРГЭЭНЭ. |
| "ХӨХ МОРЬ" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР<br>• Орхон-Онги төсөл<br>• Хэрлэн-Тооно төсөл | ГОВИЙН БҮСИЙН АХУЙН БОЛОН ҮЙЛДВЭРИЙН УСНЫ ХЭРЭГЦЭЭГ ХАНГАНА. | ХҮЛЭМЖИЙН ХИЙГ ЖИЛД 30-40 МЯН.ТОННООР БУУРУУЛНА. |
|  УЛААНБААТАР ХОТЫН ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН БАЙГУУЛАМЖИЙГ ШИНЭЧЛЭХ | ДАХИН БОЛОВСРУУЛСАН ХОГ ХАЯГДАЛ | НИЙТ ХОГ ХАЯГДАЛЫН 40%-Г ДАХИН БОЛОВСРУУЛНА. |

# ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО: НОГООН ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТ-ТЭРБУМ МОД

ТЭРБУМ МОД
ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

## ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ




ДОРОЙТСОН ОЙГ НӨХӨН СЭРГЭЭХ
707.8 сая

ЦӨЛЖИЛТ, ГАЗРЫН ДОРОЙТЛЫГ БУУРУУЛАХ
456.1 сая

НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ
156.2 сая

**1.3 ТЭРБУМ МОД**

# ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО: ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН СЭРГЭЛТ

### ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМЖУУЛАХ

Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна.

### ЗАСГИЙН ГАЗРЫН ОНОВЧТОЙ БҮТЦИЙГ ТОГТООХ

Засгийн газрын бүтэц, зохион байгуулалтад цогц шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгч, оновчтой бүтцийг тогтоон, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлнэ.

### ТӨРИЙН ДАВХАРДСАН ТОГТОЛЦООГ ЦЭГЦЭЛЖ, ЗӨВШӨӨРЛИЙН ТООГ БУУРУУЛАХ

Төрийн хяналт, шалгалтын давхардсан тогтолцоог цэгцэлж, төлөвлөгөөт шалгалтыг түр хугацаанд зогсоож, төрийн байгууллагаас шаарддаг тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлийн тоог бууруулна.

### ТӨРИЙН АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮР АШИГ, ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ

Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна.

### АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙГ БУУРУУЛАХ

Авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгана.

### ҮР АШИГТАЙ, ХАРИУЦЛАГАТАЙ САНХҮҮГИЙН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ

Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага (ФАТФ)-аас гаргадаг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсын жагсаалт (саарал, хар жагсаалт), Европын холбооны "Татварын зорилгоор хамтран ажилладаггүй бүс нутгуудын жагсаалт"-д орохгүй байх, Монгол Улсын ээлжих зэрэглэлийг бууруулахаас сэргийлнэ.

# ТӨРИЙН АЛБАНЫ ӨНӨӨГИЙН БҮТЭЦ

ТӨРИЙН ЗАХИРГАА, УЛС ТӨРИЙН АЛБАН ХААГЧ*
**24,200**

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧ*
**45,500**

ШҮҮГЧ, ПРОКУРОР
**1,100**

СОЁЛ, УРЛАГИЙН АЖИЛТАН
**4,500**

БАГШ
**50,200**

ЭМЧ, СУВИЛАГЧ, АСРАГЧ
**25,400**

ШИНЖЛЭХ УХААНЫ АЖИЛТАН
**1,700**

БҮХ ШАТНЫ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧИД
**51,600**

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
**9,700**

ТӨК, ТӨҮГ, ОНӨҮГ АЛБАН ХААГЧИД
**78,200**

ЦАЛИНГИЙН САН
**2.8** ИХ НАЯД ТӨГРӨГ

ТӨСВӨӨС ЦАЛИНЖДАГ
**НИЙТ ТӨРИЙН АЛБАН ХААГЧ**
**204,200**

+87,900

**=292,100**

# АВЛИГА, ХҮНД СУРТАЛ

АВЛИГЫН ТӨСӨӨЛЛИЙН ИНДЕКС

| БАЙР | УЛС | ОНОО |
|---|---|---|
| 1 | Шинэ Зеланд | 88 |
| 4 | Сингапур | 85 |
| 4 | Швед | 85 |
| 10 | Герман | 80 |
| 18 | Япон | 73 |
| 22 | Франц | 71 |
| 27 | АНУ | 67 |
| 32 | БНСУ | 62 |
| 36 | Израиль | 59 |
| 42 | Итали | 56 |
| 85 | Энэтхэг | 40 |
| 102 | Шри Ланка | 37 |
| 110 | **МОНГОЛ** | **35** |
| 117 | Филиппин | 33 |

**110-т ЭРЭМБЭЛЭГДСЭН**

# ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО: ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН СЭРГЭЛТ

- ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМЖУУЛАХ
- АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙГ БУУРУУЛАХ
- ТӨРИЙН ЧИГ ҮҮРГИЙН ДАВХАРДАЛ, ХИЙДЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ТООГ БУУРУУЛАХ
- ТӨРИЙН АЖ АХУЙН НЭГЖИЙН ҮР АШИГ, ЗАСАГЛАЛЫГ САЙЖРУУЛАХ
- ЗАСГИЙН ГАЗРЫН ОНОВЧТОЙ БҮТЦИЙГ ТОГТООХ
- ҮР АШИГТАЙ, ХАРИУЦЛАГАТАЙ САНХҮҮГИЙН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ

ЗӨВШӨӨРЛИЙН ТОО 2 ДАХИН

АВЛИГЫН ИНДЕКС, ЭЗЛЭХ БАЙР 2 ОРОНТОЙ ТОО РУУ ОРНО

БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИНЭ.

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРТЭЭМЖТЭЙ, ЧАНАРТАЙ, ШУУРХАЙ БОЛГОНО.

ЧАДВАРЛАГ, ЦОМХОН ТӨР

ТӨХК-ийг олон нийтийн болгох

- Засаглал сайжирна.
- Ил тод байдал хангагдана.
- Ашигт ажиллагаа нэмэгдэнэ.

Зээлжих зэрэглэл одоогийн түвшнээс буурахгүй.

# ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО: ХОТ ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ

### УЛААНБААТАР ХОТЫН АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ

Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн чанар, стандартыг сайжруулан, багтаамж ихтэй шинэ төрлийн нийтийн тээврийн хэрэгслийг нэвтрүүлэн, гол ба үндсэн авто зам, замын байгууламжийн сүлжээг өргөтгөн шинэчилж, олон түвшний уулзварыг байгуулан хүртээмжийг нэмэгдүүлж, авто замын түгжрэлийг бууруулна.

### ШИНЭ СУУРЬШЛЫН БҮС, ДАГУУЛ ХОТ, ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ

Шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулна.

### АЙМГИЙН ТӨВҮҮДИЙГ БИЕ ДААСАН ХОТ БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ

Аймгийн төвүүдийг бие даасан хот болгон хөгжүүлж, орон нутаг төсвийн орлогоо бие даан бүрдүүлэх санхүү, эдийн засгийн боломжийг бүрдүүлнэ.

### ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ

Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг дэмжиж, хүнсний дотоодын хэрэгцээг хангаж, экспортын хувь хэмжээг нэмэгдүүлнэ.

# УЛААНБААТАР ХОТЫН
# ХЭТ ТӨВЛӨРӨЛ

УЛААНБААТАР ХОТ МОНГОЛЫН ГАЗАР НУТГИЙН **0.3%**

НИЙТ ХҮН АМЫН УЛААНБААТАР ХОТОД **48.3%**

НИЙТ ИХ ДЭЭД СУРГУУЛЬ **89%**

НИЙТ ОЮУТАН **95%**

БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР **50%**

БАРИЛГА УГСРАЛТ **95%**

ИДЭВХТЭЙ ААН, БАЙГУУЛЛАГА **64%**

МОНГОЛ УЛСЫН ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ **70%** УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛДВЭРЛЭГДДЭГ

АНХНЫ ТӨЛӨВЛӨЛТӨӨС ХЭТЭРСЭН **3x**

ХОТ РУУ ЧИГЛЭСЭН ХӨДӨЛГӨӨН ЖИЛД ДУНДЖААР **15-25K**

# УЛААНБААТАР ХОТЫН
# ХЭТ ТӨВЛӨРӨЛ




**8.9км/ц** ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОХ ДУНДАЖ ХУРД

**3х** ГОЛ ЗАМУУДЫН СҮЛЖЭЭНИЙ ДААЦ ХЭТРЭЛТ

## ТҮГЖРЭЛД

ӨДӨРТ **2.5цаг**

ЖИЛД **36цаг**

МОНГОЛ УЛСЫН

# БҮС ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ БА ЭДИЙН ЗАСАГ




Аймгуудын өрсөлдөх чадварын үзүүлэлт - 2020

Монгол Улсын төсөвт төвлөрүүлэх орлого (сая төг) - 2022

Монгол Улсын төсвийн дэмжлэг (сая төг) - 2022

Монгол Улсын төсөвт орлого төвлөрүүлдэг

**6 АЙМАГ**

Монгол Улсын төсвөөс дэмжлэг авдаг

**15 АЙМАГ**

**2022 ОНЫ УЛСЫН ТӨСӨВТ ОРЛОГО ТӨВЛӨРҮҮЛЭХ АЙМГУУД**

| | | |
|---|---|---|
| 1 | Дорноговь | ₮4.6 тб |
| 2 | Дорнод | ₮5.7 тб |
| 3 | Өмнөговь | ₮264.7 тб |
| 4 | Сэлэнгэ | ₮3.1 тб |
| 5 | Дархан-Уул | ₮1.7 тб |
| 6 | Орхон | ₮91 тб |
| Нийт дүн | | ₮538.9 тб |

# ОРОН НУТАГТ ҮҮСЧ БУЙ
# **ТУЛГАМДСАН АСУУДЛУУД**

**НУТГИЙН ПОТЕНЦИАЛЫГ ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТ АШИГЛАХГҮЙ, ХҮНИЙ НӨӨЦГҮЙ**

**НУТАГ ОРОН ЭЗГҮЙДЭХ**

**МАЛЧИН ИРГЭДИЙН ЗАЛГАМЖ ТАСАЛДАХ**

**ЭРҮҮЛ МЭНД БОЛОВСРОЛ ЧАНАР**

15-34 насны малчид 1990 онд нийт малчдын 56% эзэлж байсан бол 2021 онд 28% эзлэх болж залуу малчдын хувь буурсаар байна. Огт гэрлээгүй 15-34 насны малчдын 85% нь эрэгтэй байна.









# ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ

## ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР

# НЭГДҮГЭЭР ШАТ

## 1

### НЭЭЛТТЭЙ АЙМАГ

- Welcome хөтөлбөр буюу эдийн засгийн идэвхитэй байдал /индекс/
- Шилжин суурьших хүсэлтэй иргэдийн бүртгэл- Улаанбаатар хот
- Аймгуудын "Nick name" ийг солих Жишээ нь: "Холын цэнхэр Ховд"-оос "Нутгаа өргөсөн Ховчууд"

## 2

### МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГАА

- Зерэг, сөрөг контентууд
- Сайн жишээнүүдийг сурталчилах
- Хотжилтийн талаар VS Найрсаг нутаг
- Зөөлөн дэд бүтэц буюу цахим системийн тусламжтайгаар үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх

## 3

### ШИНЭ НУТАГ- ШИНЭ БОЛОМЖ

- Шинэ цагийн илгээлтийн ээлд
- Brain to Countryside – нэн шаардлагатай эмч, багш нарын эх оронч хөдөлгөөн
- ИДС төгсөгчдтэй хамтрах
- Аймаг бүрт Кембридж

## 4

### ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

- Орон нутгийн гол капитал дээр тулгуурлаж өрсөлдөж чадах үйлдвэрүүд- Ноос, мах боловсруулах жишиг үйлдвэр
- Хөрөнгө оруулалтын хуваарилалтыг оновчлох схем гаргах
- Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд бүтээн байгуулалтын төсөл ажлын байртай уялдуулах

## 5

### ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Орон нутаг, бүсчлэлийн аргазүй, хандлагын шилжилт /өрсөлдөх чадвар, уялдаа, ТХГНын чиглэл, цахим/
- ТХХТ хүрээнд ААН-ыг орон нутагт татах
- Эдийн засаг, цалингийн бүсчлэлийг танилцуулах
- Малжуулах хөдөө аж ахуйн төсөл, хөтөлбөрийг эргэн харах
- Ипотекийг амины орон сууцжуулах хөтөлбөртэй уялдуулах

# ХЭРЭГЖИХ ХУГАЦАА

Үйл ажиллагаа эхлэх: **2022.11 сар**
Үйл ажиллагаа дүгнэх: **2024.12 сар**

**2022**
**11 САР**

Дэд ажлын хэсгүүд байгуулагдана.

Үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө боловсруулна.

**2023**
**2 САР**

Аймгууд хөтөлбөрөө боловсруулж зарласан байна.

**2023**
**3 САР**

Засгийн Газар бодлогын шийдвэрүүдийг гаргана.

**2024**
**4 САР**

Эхний хэрэгжилтийн үр дүнг нийтэд мэдээлнэ.

# ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

# **УДИРДЛАГА**

ТӨСӨЛ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ**

**2022 оны ... сарын ...-ны өдөр** **Дугаар...** **Төрийн ордон**

**Ажлын хэсэг байгуулах тухай**

1. "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дэвшүүлсэн хот хөдөөгийн сэргэлт зорилтыг хангах, Улаанбаатар хотоос хөдөө орон нутагт шилжин суурьшсан иргэдийн ажиллах, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгжүүдийг дэмжих цогц бодлогыг судлан боловсруулж, хэрэгжилтийг эрчимжүүлэх, бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг орон нутагт тэгш хуваарилах, уялдуулах үүрэг бүхий "Хөдөөгийн сэргэлт – Зорилтот хөтөлбөр"-ийг удирдан зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулсугай.
2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар батласугай.
3. Ажлын хэсгийн ажиллах удирдамж, үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөө, төсөв батлуулахыг Ажлын хэсэг /Б.Баярмагнай/-т үүрэг болгосугай.
4. Ажлын хэсгийн үйл ажиллагааг зохион байгуулахдаа Хууль тогтоомж, "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" УИХ, Засгийн газар, Нутгийн өөрөө удирдах байгууллагаас баталсан хэрэгжүүлж буй эрх зүйн актууд, орон нутагт хэрэгжиж буй хөгжлийн төсөл хөтөлбөрүүд, аймгийн засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хийж байгаа ажилтай уялдуулахыг Ажлын хэсэг /Б.Баярмагнай/-т даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

ТӨСӨЛ

Ерөнхий сайдын 2022 оны ... дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

**АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга: Батлан хамгаалахын дэд сайд; Б.Баярмагнай

Гишүүд:

Эдийн засаг, хөгжлийн дэд сайд;
Гадаад харилцааны дэд сайд;
Сангийн дэд сайд;
Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд;
Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд;
Барилга, хот байгуулалтын дэд сайд;
Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд;
Зам, тээврийн хөгжлийн дэд сайд;
Соёлын дэд сайд;
Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд;
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд;
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд;
Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд;
Эрчим хүчний дэд сайд;
Эрүүл мэндийн дэд сайд;
21 аймгийн Засаг даргын орлогч нар;
Ерөнхий сайдын зөвлөх /зөвшилцсөнөөр/

Нарийн бичгийн дарга:

ЗГХЭГ-ын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын дарга /зөвшилцсөнөөр/

Ажлын алба:

Ажлын албаны 3-5 ажилтан

МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

Мандалгови

Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 157 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд иргэдийн оролцоонд тулгуурлан томоохон төсөл хөтөлбөрийг тодорхойлох, зураг, төсвийг холбогдох газруудтай хамтран батлуулах, биелэлтийг тооцон ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | М.Анхбаяр | (Аймгийн Засаг даргын орлогч) |
| Гишүүд: | Н.Түвшинжаргал | (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга) |
| | Г.Энхтайван | (Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга) |
| | Л.Баярсайхан | (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга) |
| | М.Болор-Эрдэнэ | (Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн) |
| | Э.Чапаевдорж | (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга) |
| | Ж.Өлзийжаргал | (Улсын бүртгэлийн хэлтсийн дарга) |
| | Ж.Уянга | (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн) |
| | О.Хулан | (Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга) |
| | Ц.Уранбаямба | (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга) |
| | Б.Мөнхжаргал | (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга) |
| | Б.Алтангэрэл | (Эрүүл мэндийн газрын дарга) |
| | М.Тулгацэцэг | (Татварын хэлтсийн дарга) |
| | Ц.Сувдантуяа | (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга) |
| | Н.Гантулга | (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга) |
| | Х.Цогзолмаа | (Соёл, урлагийн газрын дарга) |
| | Б.Энхтуяа | (Статистикийн хэлтсийн дарга) |
| | Н.Даариймаа | (Хяналт шинжилгээний үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч) |
| | Г.Оюунтунгалаг | (Төрийн үйлчилгээ-Олон нийтийн мэдээллийн ажилтан) |
| | Д.Алтантогос | (Иргэний нийгмийн сүлжээ төрийн бус байгууллагын тэргүүн) |
| | Сумдын Засаг дарга нар | |
| Нарийн бичгийн дарга: | Н.Эрдэнэ-Очир | (Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга) |

4522111307

2. Төлөвлөгөө гарган батлуулж, томоохон төсөл хөтөлбөрийг тодорхойлох, зураг, төсвийг холбогдох газруудтай хамтран батлуулах, биелэлтийг тооцон ажиллах,шилжилт хөдөлгөөний мэдээллийг иргэдэд хүргэх, мэдээ, мэдээллийг холбогдох газруудад хүргэх шуурхай ажиллахыг ажлын хэсэг (М.Анхбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

**Ажлын хэсэг нь дээрх зорилгын хүрээнд дараах ажлыг хийгээд байна.**

1. **Хотоос хөдөөд шилжин суурьших иргэдийн тоог нэмэгдүүлэхэд нөлөөлөх хууль эрх зүйн зохицуулалт, өөрчлөлт оруулах шаардлагатай хууль, тогтоомжийн санал**
2. **Дундговь аймагт байгуулах боломжтой томоохон үйлдвэр дэд бүтцийн 3 санал /Гипсэн хавтан шохойн блокны үйлдвэр, малын тэжээлийн ургамал тариалах, ОУ-ын тээвэр логистикийн төв байгуулах/**
3. **Ажлын төлөвлөгөө боловсруулан хүргүүлээд байна.**

**Сумдууд дээрх 3 асуудал саналд ирүүлэх шаардлагатай.**

# ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ

**2022 оны 04 сарын 29-ний өдөр**

# 13 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ

13.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална:

13.1.1.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;

13.1.2.энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох;

13.1.3.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх;

13.1.4.төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх;

**13.3.Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно:**

13.3.1.хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах;

13.3.2.хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ;

13.3.3.техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ

# ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

**2022 оны 04 сарын 22-ны өдөр**

**2022 оны 06 сарын 10-ны өдөр**

20.4.Захиалагч тендерийн баталгааны хэмжээг төсөвт өртгийн 0.5 хувиар тогтоож тендерийн баримт бичигт тусгана.

43.2.Захиалагч гүйцэтгэлийн баталгааны дүнг тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувиар тогтоож тендерийн баримт бичигт тусгана.

45.3.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээний хувьд тухайн шатны Засаг дарга захиалагч байна.

47.4.Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотоос бусад орон нутагт аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.


ДУНДГОВЬ
АЙМАГ
ИРГЭДИЙН
ТӨСӨВ
2022 ОНЫ БАТЛАГДСАН ТӨСВИЙН
МЭДЭЭЛЛИЙГ АШИГЛАВ



Дундговь аймаг "ИРГЭДИЙН ТӨСӨВ - 2022"
АЙМГИЙН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (сая
1,082.6
Зам тээвэр
12,809.6
Боловсрол, спорт
2,117.1
Хот тохижилт
17,040.6
Барилга, хот байгуулалт
1,615.6
Нутгийн удирдлага
2,050.6
Соёл
2,026.2
Байгаль орчин, аялал жуулчлал
3,246.8
Хүнс, хөдөө аж ахуй
3,952.1
Хөдөлмөр, нийгмийн хамгаалал
3,742.1
Эрчим хүч
1,341.2
Эрүүл мэнд
1,608.8
Бусад
Нийт
52,633.3
Эх үүсвэрээр:
20,070.4
Улсын төсөв
8,101.0
Сумын ОНХС
3,063.3
Аймгийн төсөв
4,224.8
Аймгийн ОНХС
196.4
Сумын төсөв
16,977.5
Бусад
14

# АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА.